

Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт /Гаалийн ерөнхий газар/

№	Үйл ажиллагаа, арга хэмжээ	Хүрэх үр дүн	Санхүүжилтийн эх үүсвэр	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ /сая.төг/	Хэрэгжилт /2024 оны байдлаар өссөн дүнгээр/	Хариуцах газар
8	1.1.8. Гаалийн хяналтын бүсүүдэд ухаалаг гарц, орчин үеийн өндөр хүчин чадал бүхий рентген болон хяналтын тоног төхөөрөмж, лаборатори байгуулах	Боомтуудад орчин үеийн өндөр хүчин чадал бүхий рентген, дээж авагч тоног төхөөрөмж, гаалийн лаборатори суурилуулсан байна.		-	<p><u>Ухаалаг гарцын системийн тоног төхөөрөмж:</u> Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа гаалийн шинэчлэлийн хүрээнд боомт руу орох, гарах хаалга болон боомт доторх замын эгнээнүүд дээр ухаалаг гарцын системийн тоног төхөөрөмжүүдийг суурилуулж, боомтын тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтыг сайжруулахаар ажиллаж байна:</p> <p>1.Гашуунсухайт боомтын нүүрсний терминалын экспортын хэсгийн 4, импортын хэсгийн 3 эгнээ замд тус бүрт нь ухаалаг гарцын тоног төхөөрөмжийг түр суурилуулан 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн тээврийн хэрэгслүүдийг бүртгэсэн. Гэвч Гашуунсухайтын боомтын шинэчлэл, бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор түр суурилуулсан дээрх ухаалаг гарцын тоног төхөөрөмжөөс 2 иж бүрдлийг үлдээгээд бусад ухаалаг гарцын төхөөрөмжийг 2023 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр буулгаж, түр хугацаагаар агуулахад хураасан. Гашуунсухайт боомтын бүтээн байгуулалтыг үе шаттайгаар дуусгаж, улсын комисст хүлээлгэн өгөх бэлтгэл ажлууд хийгдэж байна. 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар тус боомтын:</p> <p>1.Нүүрсний терминалын: -хилээр гарах хэсэгт 21; -хилээр буцаж орох хэсэгт 14;</p>	ГЕГ

					<p>2.Зорчигчийн терминалын: -хилээр гарах хэсэгт 9; -хилээр орох хэсэгт 11; 3.Зэсийн баяжмалын: -хилээр гарах хэсэгт 2; -хилээр орох хэсэгт 2 буюу нийт 59 эгнээ замд ухаалаг гарцын тоног төхөөрөмж суурилуулах ажлыг боомтын бүтээн байгуулалтын ажилтай уялдуулан гүйцэтгэж байна.</p> <p>2.Шивээхүрэн боомтын нүүрсний хэсгийн: Гарах чиглэлд: -Монголоос боомт руу орох чиглэлд 1; -Боомтоос Хятад руу гарах чиглэлд 6; Орох чиглэлд: -Хятадаас боомт руу орох чиглэлд 2; -Боомтоос Монгол руу орох чиглэлийн 1 эгнээ замд суурилуулсан ухаалаг гарцын иж бүрдэл төхөөрөмжөөр 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн тус боомтоор нэвтрэх тээврийн хэрэгслийг бүртгэж байна.</p> <p>3.Замын-Үүд боомтын: -зорчигч тээврийн терминалын импортын хэсэгт суурилуулсан 24, экспортын хэсэгт суурилуулсан 30 буюу нийт 54 байршилд тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг ухаалаг гарын системийн тоног төхөөрөмжөөр бүртгэж байна.</p> <p>-ачааны терминалын экспортын хэсгийн 11, импортын хэсгийн 28 гарц буюу нийт 39 байршилд ухаалаг гарцын системийн тоног төхөөрөмжийг 2023 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр хийж дуусгасан. Ачааны терминалын үйл ажиллагааг 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлүүлж, 14 байршилд суурилуулсан ухаалаг гарцын системийн тоног төхөөрөмжөөр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг бүртгэж байна.</p> <p>4.Ханги боомтын бүтээн байгуулалтын ажил эхлээгүй байгаа тул тус боомтод ухаалаг</p>
--	--	--	--	--	---

					<p>гарцын системийн тоног төхөөрөмж суурилуулахтай холбоотойгоор урьдчилсан байдлаар:</p> <p>-Ухаалаг гарц байгуулах 10 цэгийн байршил; -Импорт талд 40 м урттай автопүү суурилуулах байршил ;</p> <p>-Цахилгаан болон шилэн кабелийн эх үүсвэрийг тус тус тодорхойлж, шугам татах хэсгийг товловсон.</p> <p>РЕНТГЕН:Хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд хийгдэх шалгалтын хугацааг багасгах, боомтоор нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгслийн тоог нэмэгдүүлэх, мөн хилийн хяналтын албан хаагч нарын оролцоог багасгах зорилгоор автозамын хилийн боомтуудад 5-12 км цагийн хурдтай явж байгаа тээврийн хэрэгсэлд ачсан барааг шалгах ИСБ-А рентгенийг боомтын бүтээн байгуулалттай уялдуулан үе шаттайгаар суурилуулж байна.</p> <p>Шивээхүрэн боомтод ОХУ-д үйлдвэрлэгдсэн ИСБА-005 рентгенийг 2022 оны 05 дугаар сарын 28-ны өдөр суурилуулаад тус боомтоор өдөртөө гарч байгаа 700 орчим нүүрс ачсан тээврийн хэрэгслээс 85-95 орчмыг нь рентгенээр шалгаж байна. /15 хувь/</p> <p>Боршоо боомтод суурилуулсан ОХУ-д үйлдвэрлэгдсэн ИСБА-007 рентгенийг 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдөр хүлээн авсан бөгөөд өнөөдрийн байдлаар тус боомтоор өдөртөө хилээр орж байгаа 7-8 тээврийн хэрэгслээс 3-4 орчмыг нь рентгенээр шалгаж байна. /50 хувь/</p> <p>Замын-Үүд боомтын ачааны терминалын бүтээн байгуулалтын ажлыг дуусгаж, 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдрөөс ажиллуулж байна. Тус боомтын бүтээн байгуулалтын ажилтай уялдуулан ОХУ-д үйлдвэрлэгдсэн ИСБА-006 рентгенээр өдөртөө 120-145 орчим</p>
--	--	--	--	--	---

					<p>ачаатай тээврийн хэрэгслийг шалгаж байна./23 хувь/</p> <p>Бичигт боомтод суурилуулахаар төлөвлөсөн 009 рентгеныг боомтын бүтээн байгуулалттай уялдуулан Замын-Үүд боомтын экспортын хэсэгт суурилуулахаар төлөвлөн гэрээний төслөө боловсруулж, 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01/408 албан бичгээр ИСБА компанид хүргүүлсэн. ОХУ-ын компанид захиалгын дагуу үйлдвэрлэгдэж байгаа.</p> <p>Булган боомтод ИСБА 008 рентгеныг нийлүүлэгч компаниас 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдөр хүлээн авч, тус рентгеныг суурилуулахаар төлөвлөсөн байрлал нь одоогийн боомтын барилгын байрлалд давхацсан тул байршлыг нь өөрчилсөн. ОХУ-ын ИСБА компаниас дээрх рентгеныг 2024 оны 08 дугаар сарын эхний 10 хоногт хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.</p> <p><u>ЛАБОРАТОРИ</u>: МУ-ын ЗГ-аас хэрэгжүүлсэн гаалийн шинэчлэлийн хүрээнд 2020-2023 хооронд Гаалийн төв болон салбар лаобраториуд (Сэлэнгэ аймгийн Алтанбулаг боомт, Дорнод аймгийн төв болон Баянхошуу боомт, Замын-Үүд, Өмнөговь аймгийн ГСГГ-ОТ, Сайншанд, Ховд аймгийн Булган боомт, Баян-Өлгий аймгийн Цагааннуур боомт, Орхон аймаг, Увс аймгийн Боршоо боомт, Чингис Хаан олон улсын нисэх буудал, Орхон аймаг гаалийн газрын) нь уул уурхайн эрдэс түүхий эд, нүүрс, газрын тосны бүтээгдэхүүн, химийн бодис, бэлдмэл, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис, ноос ноолуур малын гаралтай ширхэгт бүтээгдэхүүн, ээрмэл, сүлжмэл бүтээгдэхүүнд барааны ангиллын код тодорхойлох, хүнсний бүтээгдэхүүнд эрүүл ахуй, чанар аюулгүйн шинжилгээ, ургамал хорио цээрийн шинжилгээний зориулалттай тоног</p>	
--	--	--	--	--	---	--

					<p>төхөөрөмжийг захиалж, хүлээн авч, шалгалт тохируулга хийж, хэвийн үйл ажиллагаанд оруулан, магадлан шинжилгээг хийж гүйцэтгэж байна.</p> <p>Харин Гашуунсухайт боомтын хяналтын бүсэд байгуулагдаж буй нүүрсний лабораторийн барилгын бүтээн байгуулалт 90%-тай явж байгаа тул нүүрсний шинжилгээний 23 тоног төхөөрөмжийг сав, баглаа боодлоор нь түр хүлээн авсан, ЗҮ боомт дахь гаалийн лабораторийн барилгыг нүүрсний шинжилгээний зориулалтаар засварлах зургийг гарган ГЕГ-ын СХОГ болон "Голомт Өргөө" ХХК-д хүргүүлсэн бөгөөд нүүрсний шинжилгээний 20 тоног төхөөрөмжийг сав, баглаа боодлоор нь хүлээн авсан.</p>	
9	1.1.9. Гаалийн хяналт, бүрдүүлэлт, лабораторийн үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлж, хилийн хяналт шалгалтад зарцуулах хугацааг бууруулах	Хилийн хяналт шалгалтад зарцуулах хугацаа 26-аас доошгүй хувиар буурсан байна.			<p>ГЕГ-ын дэд даргын 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдөр баталсан удирдамжаар байгуулагдсан ажлын хэсэг “Бүрдүүлэлтийн цаг хугацааны 2023 оны судалгаа”-г хийж, 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдөр тайлангаа гаргалаа. Судалгаанд Бүрдүүлэлтийн цаг хугацааны өмнөх 5 удаагийн судалгааны дүн, 2019, 2022, 2023 оны судалгаанд хамрагдсан 17352 гаалийн мэдүүлэг, 100152 барааны бичлэгт хамаарах, таван дэд программаас авсан давхардсан тоогоор 18 төрлийн 266309 мянган өгөгдөл/мэдээллийг хамруулсан. Сонгож авсан хугацаанд гаалийн газар, гаалийн хяналтын бүсэд хийгдсэн бүрдүүлэлтийн мэдээллийг CAIS-ийн 5 дэд программаас татаж, харьцуулан, хилийн гаалийн байгууллага дээр, хилээс гүний гаалийн байгууллагын хяналтад илгээж, барааг эзэнд нь олгох хүртэлх цаг хугацааг тооцоолон, өмнөх судалгаатай харьцуулж, цаг хугацааны</p>	ГЕГ

					<p>өөрчлөлтийг гаргасан.</p> <p>ГЕГ-ын 2019 оны Бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгаатай 2023 оны судалгааг сонгон авсан гаалийн газар, хороодоор харьцуулахад “Тээвэрлэлт, Татвар төлөх хугацаа, Хорио цээрийн шалгалт, Гаалийн лабораторийн шинжилгээ”-нд зарцуулсан хугацаа нь бүрдүүлэлтийн цаг хугацааг нэмэгдүүлэхэд хамгийн их нөлөө үзүүлжээ.</p> <p>Бүрдүүлэлтийн цаг хугацааны 2023 оны судалгааг 2019 оны судалгаатай харьцуулахад зөрүүтэй байгаа нь өгөгдөл/мэдээлэл цуглуулсан, боловсруулсан аргачлалын хувьд ялгаатай байгаатай холбоотой. Үүнтэй уялдуулан 2 судалгааны ижил болон ялгаатай талыг харьцуулан харуулсан. “Татвар төлөх хугацаа” нь бүрдүүлэлтийн цаг хугацааг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн ба 2022 онд дунджаар 20 цаг, 19 минут, 2023 онд дунджаар 19 цаг 38 минут тус тус зарцуулсан. Мэдүүлэгч нар бараагаа хүлээж авахгүй цаг хугацаа алдаж байгаа нь улаан төлөвтэй мэдүүлэгт хяналт, шалгалт хариуцсан гаалийн улсын байцаагч, улбар шар, ногоон төлөвтэй мэдүүлэгт хяналт, шалгалт хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч дээр хуваарилагдсан цаг хугацааг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн.</p> <p>Мөн хяналтын улбар шар болон ногоон төлөвт сонгогдсон гаалийн бүрдүүлэлтийн хугацаа улаан төлөвтэй бараг ойролцоо гарсан нь “Татвар төлөх хугацаа” өндөр байгаатай холбоотой бөгөөд нэг болон олон нэр төрөлтэй бараа эсэхээс үл хамаарч бичиг баримт болон бараанд хийх шалгалтад ижил хугацаа, эсхүл нэг нэр төрлийн бараанд илүү хугацаа зарцуулсан байсан.</p> <p>Шинжилгээг голч утга (медиан)-аар авч үзэхэд гаалийн бүрдүүлэлтэд зарцуулсан хугацаа 2023 онд 267.5 минут байгаа нь 2022 оны мөн</p>	
--	--	--	--	--	--	--

				<p>үетэй харьцуулахад 25 хувиар өссөн бөгөөд үүнд хорио цээрийн шалгалтад 2023 онд зарцуулсан дундаж хугацаа болох 841 минут/14 цагийг 2022 оны мөн үетэй харьцуулахад 136 минут/16 хувиар өссөн нь нөлөөлжээ. Шинжилгээний үр дүнд “Хорио цээрийн шалгалт болон ГУАБ зөвшөөрөх” үе шат нь дундаж хугацаанаас хэт хазайлттай гарсан. Энэ нь тухайн үе шатанд тооцоолол хийхэд хүндрэл учруулах эрсдэлийг бий болгожээ. Бусад үе шатын хувьд 40-124 минут/0.7-2.06 цагаар буурсан байна.</p> <p>Бүрдүүлэлтийн үе шат бүрээс бичиг баримтын шалгалтад зарцуулсан дундаж хугацааг 2022 оны мөн үетэй харьцуулахад 124 минут буюу 2.77 дахин буурсан нь бичиг баримтын шалгалтыг нэг цэгт төвлөрүүлсэнтэй холбоотой.</p> <p>Энэхүү судалгааны шинжилгээг дундаж утгын хүрээнд авч гүйцэтгэхэд 2023 онд гаалийн бүрдүүлэлтэд зарцуулсан хугацааг 2022 оны мөн үетэй харьцуулахад 8 хувиар бууруулсан дүн гарсан. <u>Лабораторийн удирдлагын нэгдсэн систем (LIMS)</u></p> <p>Гаалийн төв лаборатори болон салбар газар, хороодын лабораторид ашиглах “ЛИМС” /lms.ecustoms.mn/ системийн хөгжүүлэлтийг “Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв” УҮГ-тай хамтран боловсруулж, ГТЛ болон салбар газар, хороодын лабораторид үе шаттайгаар нэвтрүүлсэн. Гаалийн төв лабораторийн 68 дугаар дотоод зурвасаар Мэдээллийн технологийн газарт ирүүлсэн программын даалгаврын дагуу дараах засвар, өөрчлөлтийг хийсэн. Үүнд:</p> <ol style="list-style-type: none">1. Засгийн газрын 362 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд CAIS системийн дүгнэлтийн программын үндсэн мэдээлэл дээр	
--	--	--	--	---	--

					<p>экспортлож буй эрдэс, түүхий эд, нүүрсний аж ахуйн нэгжүүдийн АМНАТ-ын зөвшөөрлийн дугаарыг шинээр тусад нь хүснэгт болгон оруулах, нөхөж бичих, засварлах боломжийг бүрдүүлсэн.</p> <p>2. Гэрээний тоо, хэмжээ дууссан эсвэл тухайн ААН нь дүгнэлт авахаас татгалзсан зэрэг шалтгаанаар дүгнэлт гарах боломжгүй тохиолдолд дүгнэлт илгээсэн төлвөөс "тайлбар" бичиж, хаах боломжийг CAIS программд оруулсан.</p> <p>3. 2022-2023 онд Лимс программыг төв болон салбар лабораторид нэвтрүүлж, хөгжүүлсэнтэй холбогдуулан шинжилгээний тоног төхөөрөмжийг Лимс программтай холбож, шинжилгээний үр дүнг сорилтын үр дүнгийн хуудсаар Лимсийн программаар гаргаж байна. Дүгнэлт гаргахдаа CAIS программд лимсийн программаар гарсан сорилтын дүнг гараар бичих шаардлага гарч байгаа тул үүнийг боловсронгуй болгох хүрээнд Лимс дээр гарсан сорилтын дүнг CAIS программтай холбох ажил хийгдэж байна.</p>	
10	1.1.10. Уул уурхайн бүтээгдэхүүнийг тээвэрлэх, хилээр нэвтрүүлэх тээврийн зохион байгуулалтыг боомт тус бүрээр төлөвлөх	Уул уурхайн бүтээгдэхүүний экспортод зарцуулах хугацаа буурсан байна.			<p>1.Автозамын хилийн боомтоор нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийн программыг бүрэн нэвтрүүлсэн. Үүний үр дүнд тээврийн хэрэгсэл эзэмшигч нар хилийн боомтоор нэвтрэх бүртгэлийн мэдээллийг CEPS системд өөрсдөө нөхөж бичээд, гаалийн байгууллагын CAIS системд илгээснээр экспортын эрдэс бүтээгдэхүүн ачсан тээврийн хэрэгслүүд хил дээр бүртгүүлэх зорилгоор дараалалд зогсох шаардлагагүй болсон.</p> <p>2.Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 466 дугаар тогтоолын дагуу цахим арилжаагаар экспортод гаргах нүүрсийг 2023 оны 01 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн Гашуунсухайт дахь</p>	ГЕГ

					<p>Чингэлэг тээврийн терминал гаалийн хяналтын бүсээр дамжуулан гаргаж байна. 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар нээлтэй цахим арилжаагаар худалдаалсан:</p> <ul style="list-style-type: none">-Эрдэнэс тавантолгой ХК-ийн 44 гэрээний 5,296,808.35 тн;-Энержиресурс ХХК-ийн 189 гэрээний 2,741,849.88 тн;-Хангад-Эксплорэйшн ХХК /ГХО/ -ийн 13 гэрээний 165,663.60 тн;-Тавантолгой ХК-ийн 4 гэрээний 309,346.1 тн нүүрсийг тус тус Гашуунсухайт боомт дахь Чингэлэг тээврийн терминал гаалийн хяналтын бүсээр дамжуулан гаргасан байна. <p>3.Шивээхүрэн чингэлэг терминалаас тээвэр хийх 4 гарцын 2 гарц нь AGV автомат удирдлагатай тээврийн хэрэгслийн тээвэрлэлтэд зориулагдаж, БНХАУ-ын Сэхээ боомттой холбогдсон. Хятадын талаас 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн AGV автомат удирдлагатай тээврийн хэрэгсэл оруулж, хоосон чингэлэг ачиж гаргах туршилтыг хийж, 2023 оны 1 дүгээр сараас AGV автомат удирдлагатай тээврийн хэрэгслээр хоосон болон нүүрс ачсан чингэлэг солилцох байдлаар нүүрс гаргаж эхэлсэн. Дээрх гарцаар 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар 516.4 мянган тн нүүрс экспортлосон байна.</p> <p>Монголын талд 5G тээвэрлэлтэд 2 гарцыг зориулж төлөвлөсөн ба 2023 оны 11 сараас эхлэн БНХАУ-ын Сэхээ боомтод тусдаа гарцаар нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж нэвтрүүлж эхэлсэн. 2022 онд хилийн зурваст хийгдэж байсан шилжүүлэн ачилтыг Чингэлэг терминалын 5G хэсэгт шилжүүлснээр 2023 онд 3.9 сая тонн, харин 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 18-ны</p>	
--	--	--	--	--	--	--

					<p>өдрийн байдлаар 2.28 сая тонн нүүрс чингэлэг терминалд чингэлэг шилжүүлэн ачилт хийж экспортолсон.</p> <p>Шивээхүрэн чингэлэг терминалаас 2023 оны 08 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн 5G жолоочгүй 5 тээврийн хэрэгслээр нүүрс экспортлох ажлыг туршилтаар эхлүүлсэн бөгөөд 2 улсын сүлжээний зөрүүтэй холбоотойгоор тээвэрлэлтийг Монгол улсын нутаг дэвсгэрт жолоочтойгоор гүйцэтгэж байна.</p> <p>2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар 18-ны өдрийн байдлаар 82.4 мянган тонн нүүрсийг 5G тээвэрлэлтээр экспортолсон.</p> <p>4.Манай улсаас уул уурхайн бүтээгдэхүүнийг автозамын хилийн Гашуунсухайт, Шивээхүрэн, Булган, Ханги, Бургастай, Бичигт, Хавирга боомтуудаар гаргаж байна. Тус боомтуудаар 2024 оны 1 дүгээр сард өдөртөө дунджаар 2090 орчим тээврийн хэрэгслээр уул, уурхайн бүтээгдэхүүн гаргаж байсан бол дээрх тээврийн хэрэгслийн тоо 2024 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн байдлаар өдөрт дунджаар 3200 орчим болсон байна.</p> <p>Гаалийн ерөнхий гаалийн Гаалийн хяналт бүрдүүлэлтийн CAIS системийн гаалийн бүрдүүлэлтийн програм, ачааны манифестын програмаас 2024 оны 06 дугаар сарын 01-10-ны өдрүүдэд нийт 14313 экспортын гаалийн бүрдүүлэлт хийгдсэн мэдээлэл цаг хугацааны судалгаа хийсэн. Экспортлогч гаалийн байгууллагад мэдүүлснээс улсын хилээр гаргасан нийт хугацаа дунджаар 1683 мин буюу 28 цаг 33 минут байна. Үүнээс 655 AVG буюу жолоочгүй тээврийн хэрэгслээр тээвэрлэгдсэн барааны хил нэвтрсэн дундаж хугацаа 1222 минут буюу 20 цаг 22 минут, 13351 автотээврийн хэрэгслээр тээвэрлэгдсэн бараанд дунджаар 1641 минут</p>	
--	--	--	--	--	---	--

					<p>буюу 27 цаг 21 минут, 307 төмөр замын тээврийн хэрэгслээр тээвэрлэгдсэн бараанд 4503 минут буюу 75 цаг 03 минут зарцуулсан байна.</p> <p>5."Эрсдэлийн судалгаа."Эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналтын үр нөлөөг дээшлүүлэх, эрсдэлт орчныг тодорхойлох, судалгаанд суурилсан шийдвэр гаргах, гаалийн байгууллагын гүйцэтгэлийг нэмэгдүүлэх, бараанд хийх шалгалтаас чөлөөлөгдсөн бүрдүүлэлтэд дэмжлэг үзүүлэх зорилгоор макро түвшний 7, микро түвшний 19 судалгааг хийж гүйцэтгэсэн. Эрсдэлийн удирдлагын программын мэдээллийн санд 9 профайлын хүрээнд 483 шалгуур үзүүлэлтийг оруулсан. Тайлант хугацаанд 540,222 гаалийн мэдүүлгээр 13.26 тэрбум ам. долларын 1.34 сая барааны бичлэгээр гаалийн бүрдүүлэлт хийж, 2.86 их наяд төгрөгийн гаалийн болон бусад татварыг улсын төсөвт төвлөрүүлжээ. Нийт бүрдүүлэлтийн импорт 35%, экспорт 65%-ийг тус тус эзэлжээ. Гаалийн бүрдүүлэлтийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад бүрдүүлэлтийн тоо 32%, барааны бичлэгийн тоо 16%, статистик дүн 14%, улсын төсөвт төвлөрүүлсэн гаалийн болон бусад татварын орлого 21%-аар тус тус өссөн байна. Эрсдэлийн удирдлагын программд оруулсан эрсдэлийн шалгуурын үр дүнд бичиг баримтын болон бараанд хийх шалгалтаас нийт мэдүүлгийн 63.1%-ийг чөлөөлсөн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 3.5%-иар өссөн эерэг үр дүн гарсан.</p> <p>“Бүрдүүлэлтийн цаг хугацааны 2023 оны судалгааны тайлан”-г хийж гүйцэтгэх ажлын хэсгийн удирдамжийг 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдөр ГЕГ-ын дэд дарга</p>
--	--	--	--	--	--

					<p>баталсан. Судалгааны ажил Хураангуй, Судалгааны арга зүй, Онол, арга зүйн үндэслэл, Монгол Улсын гадаад худалдааны өнөөгийн байдал, Бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгаа, Дүгнэлт, Санал, Хавсралтыг оролцуулсан долоон бүлэг, зургаан дэд бүлэг, долоон дэд хэсэг, 17 зураг, 40 хүснэгт, 5 хавсралтаас бүрдэнэ (80 хуудастай). Бүрдүүлэлтийн цаг хугацааны өмнөх таван судалгаа, 2019, 2022, 2023 оны судалгаанд хамрагдсан хугацаанд хийгдсэн 17,352 гаалийн мэдүүлэг ба 100,152 барааны бичлэгт хамаарах, таван дэд программаас авсан давхардсан тоогоор 18 төрлийн 266.309 мянган өгөгдөл/мэдээллийг судалгаанд хамруулсан.</p> <p>Дүгнэлт:</p> <ul style="list-style-type: none"> - Шинжилгээг дундаж утгын хүрээнд авч гүйцэтгэхэд 2023 онд 1,993.5 минут зарцуулсныг 2022 оны мөн үетэй харьцуулахад 8 хувиар буурсан. Тус бууралтад нөлөөлсөн гол үе шат нь бичиг баримтын шалгалт 64 хувиар буурсантай холбоотой. - Бүрдүүлэлтийн үе шат бүрээс онцгой ахиц дэвшил бичиг баримтын шалгалтад зарцуулсан дундаж хугацааг 2022 оны мөн үетэй харьцуулахад 124 минут буюу 2.77 дахин буурсан нь бичиг баримтын шалгалтыг нэг цэгт төвлөрүүлэн цахим хэлбэрээр хийх болсонтой холбоотой юм. <p>Цаашид:</p> <ul style="list-style-type: none"> - Гаалийн бүрдүүлэлт, Эрсдэлийн удирдлага, Зөрчил, Гаалийн лаборатори болон Тээврийн хэрэгсэл, Манифест, Пүүний программ хангамжийн мэдээллийг хооронд нь уялдуулж, хяналтын үе шат бүрийг “Гаалийн бүрдүүлэлтийн хугацаа” дэд талбарт үнэн зөв, нэг цонхоор харах боломжийг нэн даруй бүрдүүлэх;
--	--	--	--	--	---

					- Гаалийн хяналтын үе шат бүрээр (Бичиг баримт, Хорио цээр, Хяналт шалгалт) цаг хугацааны стандартыг тээврийн хэрэгслийн төрөл, барааны тоо хэмжээ, хяналт шалгалтын арга, гаалийн хяналтын төлөвтэй уялдуулан стандарт боловсруулах ажлын хэсэг гарган, гаалийн газар, хороод, чиглэл хариуцсан албаны дарга, гаалийн улсын ахлах байцаагч, байцаагч нарын ажлын гүйцэтгэлтэй уялдуулах зөвлөмж гаргах.	
15	1.4.1. Хилийн зарим боомтыг нэмж чөлөөт бүс болгон хөгжүүлэх асуудлыг судалж, шийдвэрлүүлэх	Чөлөөт бүс шинээр нэмж байгуулсан байна.			ХАМААРАЛГҮЙ	ГЕГ